

АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга	4
1.1 Төслийн товч танилцуулга	4
1.2 Баяжуулах үйлдвэрийн байршил	4
1.2.1 Газарзүйн байршил.....	4
1.2.2 Баяжуулах үйлдвэрийн газар зүйн байршил:	5
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	6
2.1 Тоосжилтыг бууруулах төлөвлөгөөт усалгааг 4-10 саруудад хур борооны давтамжаас хамааруулан 7 хоногт 2-3 удаа хийж байх	6
2.2 Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж түүнд хяналт тавьж байх	7
2.3 Машин механизмын засвар үйлчилгээг тогтмол хийх, оншилгоонд хамруулах. Чанартай түлш ашиглаж байх хэрэгтэй.	7
2.4 Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, замыг тэмдэгжүүлэх, хуучирсан тэмдэг тэмдэглэгээг сэргээх	8
2.5 Хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг ханган үйл ажиллагаа явуулах, хяналт мониторинг тогтмол хийж байх	9
2.6 Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг баримтлан үйл ажиллагаа явуулах	10
2.7 Бохир хадгалах цооног, шугам хоолойд тогтмол хяналт шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй засах арга хэмжээг авах	10
2.8 Гоожиж асгарсан ШТМ-ыг шингээх материалыг ажлын талбайд бэлэн байлгах, мөн асгаралтаас сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээ, асгаралтыг мэдээлэх, хязгаарлах, цэвэрлэх дотоод журам боловсруулж мөрдүүлж ажиллах	11
2.9 Хог хаягдлыг зориулалтын цэгт хаях, ангилах ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах	12
2.10 Тоолуурын баталгаажуулалтын цаг тухай бүрт нь хийлгэх, тоолуур эвдрэл гэмтэл гарсан тухай бүр солих	14
2.11 Худгийн тоолуурын мэдээг сар бүр суманд тайлагнах	15
2.12 Унд ахуйн болон бусад хэрэгцээнд усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах, ус хэмнэлтэт эко цорго нэвтрүүлэх	16
2.13 Хур борооны усыг хуримтлуулан тоосжилт, зам усалгаа, ногоон байгууламж услахад ашиглах	16
2.14 Худгийн барилга байгууламжийг сайжруулах, эрүүл ахуйн бүс тогтоох	16
2.15 Баяжуулах үйлдвэрийн ургамлын аймгийг тодорхойлох цэгт ургамлын мониторинг хийх	17
2.16 Хууль бусаар ан амьтан агнах, гаршуулах, гэрэл чийдэн тусгаж сэлгүүцэж амьтдыг айлгах, хөөн зайлуулах үйлдлийг хатуу хориглоно. Ажилчдад мэдлэг олгох сургалт хийх	18
2.17 Үйлдвэрийн цахилгаан шугам болон сумаас үйлдвэр чиглэлийн өндөр хүчдэлд шувуу үргээгч байршуулах	19
3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	20
3.1 Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах	20
3.2 Хүнсний хог хаягдлыг ялган авч түргэн ялзруулагч ашиглан компост бордоо хийж хүлэмжийг бордох	20
3.3 Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх	21
3.4 Ахуйн бохир усны цооногт ариутгах, халдаргүйжүүлэх, ариутах	21
3.5 Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх	22
3.6 Хаягдал усны хяналт шинжилгээ мониторингийг цах тухайд хийх	22
3.7 Ашигласан тос масло хадгалах цэгийн бүрэн бүтэн байдлыг хангах	22
3.8 Ашигласан тос маслийг мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж зайлуулах	22
3.9 Химийн бодисын шингэн үлдэгдэл болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж зайлуулах	23

4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
5.1 Даланжаргалан сумын төв замын ард байрлах мод тарих талбайг тойруулан хашаа барих	28
5.2 Даланжаргалан сумын мод тарих хашаалсан талбайд мод тарих	28
6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	29
6.1 Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TPS, PM2.5, PM10, SO2, NO2	29
6.2 Гүний худгийн усны чанар/Улиралд 1 удаа/	30
6.3 Ахуйн бохир ус /Жилд 2 удаа/	30
6.4 Хаягдлын далангийн ус /жилд 2 удаа/	30
6.5 Хөрсний ерөнхий химийн шинжилгээ /жилд 2 удаа/	31
6.6 Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж /Жилд 2 удаа/	31
6.7 Ургамлын зүйлийн бүрдэл ургамлын түсгэг бүрхэц, 1 м2 талбайгаас газрын дээрх биомасс авах	32
6.8 Дуу чимээний түвшинг хэмжих	33
6.9 Эргэлтийн усан болон хаягдлын санд ирж буй шувууд, тэдгээрийн төрөл, тоо, давтамжийн хаянах, бүртгэл хөтлөх	34
7. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
7.1 Газар, ус, агаар бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах	34
7.2 Баяжуулах үйлдвэрийн ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	35
7.3 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх	35
8. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	36
8.1 БОУАӨЯ-д цахим хэлбэрээр илгээх	36
8.2 Аймгийн БОГ-т шинжээчдийн дүнгээр баталгаажна./орон нутгийн байгаль орчны байцаагч	36
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАРДАЛ	37
ХАВСРАЛТ	38
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил	5
Зураг 2. Тоосжилтыг бууруулах замаар усалгаа хийж буй байдал	6
Зураг 3. Ойролцоо үйл ажиллагаа явуулж буй ААН хамтран батлуулахаар өгсөн замын маршрутын зураг	7
Зураг 4. Шатхууны сорилтын үр дүнгийн тайлан	8
Зураг 5. Замын тэмдэг тэмдэглэгээ	9
Зураг 6. Үйлдвэрийн хаягдлын сан	9
Зураг 7. Аюулгүй ажиллагааны дүрэм танилцуулах үйл явц	10
Зураг 8. Ахуйн бохир ус соруулж буй	10
Зураг 9. Асгаралтын иж бүрдэл	11
Зураг 10. Бохирдсон хөрс хадгалах цэг	11
Зураг 11. Ахуйн хатуу хог хаягдлын цэг	12
Зураг 12. Хуванцар сав цуглуулах	12
Зураг 13. Төмрийн хог хаягдал цуглуулах талбай	13
Зураг 14. Ашигласан тос масло цуглуулах цэг	13
Зураг 15. Химийн бодисын сав баглаа шуудайн агуулах	14
Зураг 16. Худаг №2 3 6 баталгаажуулалтын гэрчилгээ	14
Зураг 17. Худгийн тоолуурын мэдээ	15

Зураг 18. Ус хэмнэгч эко цорго суурьлуулсан байдал.....	16
Зураг 19. Худаг №2	16
Зураг 20. Ургамлын бичиглэл хийх талбайг (1x1 м) харуулсан байдал.....	18
Зураг 22. Сургалтын орсон баримт	19
Зураг 23. Шувуу үргээгч суурьлуулсан өндөр хүчдэл	19
Зураг 24. Ахуйн хатуу хог хаягдлын тээвэрлэж буй зураг	20
Зураг 25. Хүнсний хог хаягдлыг газар дээр нь ялган авч ялзруулан авч буй зураг .	21
Зураг 26. Ариутгал, халдваргүйжүүлэлт.....	21
Зураг 27. Ашигласан тос масло хадгалах цэг	22
Зураг 28. 200 л тос масло тушаасан баримт	23
Зураг 29. Химийн бодисын шуудай болон үлдэгдэл хүлээн авсан акт болон ачилтын үйл явц.....	24
Зураг 30. Төмөр хадгалах талбай болон хүлээлгэн өгсөн ак	24
Зураг 31. Мод тарих талбайд хийгдсэн хашааны зураг.....	28
Зураг 32. Ургамлын бичиглэл хийх талбайг (1x1 м) харуулсан байдал.....	32
Зураг 32. 2024 онд байршуулсан шувуу үргээгчийн зураг	34

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

“Кевин Инвест” ХХК-ийн хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн хүрээнд уг үйлдвэрийг эрдэс түүхий эдээр хангах, хүдэр баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан хэрэгжүүлэх зорилт тавигдаж байна.

Уг зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл хэмээх баримт бичгийг “Молор-Эрдэнэ Арвижих” ХХК боловсруулан Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. ТЭЗҮ-ийн дагуу баяжуулах үйлдвэр дээр бүтээн байгуулалтын ажил хийгдэж, 2008 оноос хүдэр баяжуулах үйлдвэр ажиллаж эхэлсэн.

Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголыг Эрдэс баялгийн сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаалын 7.3-д заасныг үндэслэн боловсруулав.

“Кевин Инвест” ХХК нь Монгол улсын 9019034023 бүртгэлийн дугаар бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ эзэмшдэг бөгөөд хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрлэл эрхлэх эрхийг 2007 оны 09 дүгээр сард авсан. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/121 тоот шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 10.8 га газрыг 5 жилийн хугацаатай олгосон. Уг зөвшөөрлийг 2017 онд Даланжаргалан сумын засаг даргын 2017 оны 02 сарын 01 өдрийн А/222 тоот шийдвэрээр 15 жилийн хугацаатай сунгасан.

Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь анх жилд 75 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтайгаар 2008 онд ашиглалтад орсон ба 2013 оноос үйлдвэрээ өргөтгөн жилд 150 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай ажиллаж байна.

“Талст дөл” ХХК нь 2021 оны 11 дүгээр сард тус үйлдвэрийг түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд бага агуулгатай олборлосон жоншийг худалдан авч баяжуулан 95%-с доошгүй агуулгатай жоншны баяжмал үйлдвэрлэж авто зам, төмөр замаар Үйлдвэр-Олон Овоо өртөө-БНХАУ-ын Эрээн хот гэсэн маршрутаар тээвэрлэнэ.

1.2 Баяжуулах үйлдвэрийн байршил

1.2.1 Газарзүйн байршил

Даланжаргалан сум нь Дорноговь аймгийн хамгийн баруун хойд талын сум бөгөөд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 305 км, Дорноговь аймгийн төв Сайншанд сумаас 156 км-ийн зайтай оршдог.


Даланжаргалан сум нь хойд талаараа Хэнтий аймгийн Дархан сумтай 76.4 км, Зүүн болон урд талаараа Айраг сумтай 133 км, баруун урд талаараа Дундговь аймгийн Өндөршил сумтай 10.2 км, баруун урд талаараа Дундговь аймгийн Баянжаргалан сумтай 30.1 км, баруун талаараа Говьсүмбэр аймгийн Шивээ-говь сумтай 39.1 км, баруун хойд талаараа Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумтай 43.3 км газраар тус тус хиллэнэ.

1.2.2 Баяжуулах үйлдвэрийн газар зүйн байршил:

“Кевин Инвест” ХХК-ийн “Хайлуур жонш баяжуулах үйлдвэр” төслийн талбай Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 4-р баг буюу Цомог багийн нутагт байрлана.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн солбилцол

Талбайн булангийн нэгүүд	X	Y
1	109°05'11.5"E	45°55'50.0"N
2	109°05'16.8"E	45°56'02.8"N
3	109°05'28.3"E	45°56'00.6"N
4	109°05'23.0"E	45°55'47.4"N



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Тоосжилтыг бууруулах төлөвлөгөөт усалгааг 4-10 саруудад хур борооны давтамжаас хамааруулан 7 хоногт 2-3 удаа хийж байх

Үйлдвэрийн замын усалгааны хуваарийг цаг агаарын мэдээний үндэс дээр боловсруулан тоосжилтыг дарахад 49 өдөр усалгаа хийж, уурхайн зам талбайг услахад 756 м3 ус ашигласан бөгөөд 139 860 төг болно.

Хүснэгт 2. Тоосжилтыг бууруулах усалгааны хуваарь

	2025 оны замын тоосжилт дарах усалгааны хуваарь																															Нийт өдөр	Тоосжилт /м3/	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31			
1-р сар																																	0	-
2-р сар																																	0	-
3-р сар																																	0	-
4-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	8	240.00	
5-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	7	210.00	
6-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	6	54.00	
7-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	5	45.00	
8-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	7	63.00	
9-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	6	54.00	
10-р сар	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	а	10	90.00	
Нийт ажлалх хоног, тоосжилт дарах усалгааны хэмжээ /м3/																49	756.00																	

Бороотой өдөр
 Усалгаа хийсэн өдөр



Зураг 2. Тоосжилтыг бууруулах замаар усалгаа хийж буй байдал

Үйлдвэрийн замд тогтмол усалгаа хийснээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт бууруулж, агаарын чанар сайжирна.

2.2 Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж түүнд хяналт тавьж байх

Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх үүднээс Даланжаргалан сумын Цомог багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтран уул уухайн бүтээгдэхүүний тээвэр хийж буй авто замын чиглэлийг харилцан тохиролцон Даланжаргалан сумын Засаг Даргад авто замын маршрутыг батлуулахаар хүсэлт өгсөн.

Үүнд: Замын маршрут боловсруулан батлуулах, шороон замыг өөрсдийн хөрөнгөөд хийх, замын арчилгааг тогтмол хийх, тэмдэг тэмдэглэгээг 2026 оны 2 улиралаас хийж эхлэхээр болсон.



Зураг 3. Ойролцоо үйл ажиллагаа явуулж буй ААН хамтран батлуулахаар өгсөн замын маршрутын зураг

2.3 Машин механизмын засвар үйлчилгээг тогтмол хийх, оншилгоонд хамруулах. Чанартай түлш ашиглаж байх хэрэгтэй.

Тоног төхөөрөмж, тээврийг хэрэгслүүдэд учирсан гэмтлийг цаг тухай бүрт нь хатуу хучилттай засварын талбайд засвар үйлчилгээг хийж ажилд гаргадаг.

Үйлдвэрийн үйл ажиллагаанд “Сан Петролиум” ХХК-ийн нийлүүлсэн дизель түлшийг ашигладаг бөгөөд холбогдох стандарт, техникийн шаардлагад нийцэж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор түлшний чанарын шинжилгээг эрх бүхий лабораторид хийлгэж, үр дүнд нь үндэслэн хяналт тавьж ажилладаг.

Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний
MNS ISO/IEC17025 стандартаар итгэмжлэгдсэн лаборатори

СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН №09105/25

AMBER LI

ДЭЭЖИЙН МЭДЭЭЛЭЛ				
Дэтж ирүүлсэн байгууллагын нэр	Сан Петролиум ХХК			
Дэтжигч асан газар	Сан Петролиум ХХК-ийн ГТБА, Улаанбаатар, Монгол			
Дэтжигч төрөл	Дизель түлш			
Дэтж асан объект	Нягоништери			
Дэтж асан ажилтан	Сан Петролиум ХХК-ийн ажилтан			
Дэтжигч хэмжээ	2.0 литр			
Дэтжигч ашины дугаар	-			
Дэтжигч нэмэлт тайлбар	-			
Дэтж асан огноо: 2025.11.24	Хүлээн авсан огноо: 2025.11.25	Шинжилсэн огноо: 2025.11.26		

СОРИЛТЫН ҮР ДҮН				
Үзүүлэлт	Хэмжээ нэгж	Сорилт гүйцэтгэсэн стандарт	Норм /MNS 6861:2020/ Өвөл	Үр дүн
1 15°C дахь хувиан жин, дээшгүй	g/cm ³	MNS ASTM D4052	0.8434	0.8325
Найрвлагын бүрдэлдүүрэн				
2 50% нэрэгдэх температур, дээшгүй	°C	MNS ISO 3405	280.0	247.0
95% нэрэгдэх температур, дээшгүй			360.0	313.0
3 Кинематик зууралдагч 20°C-д	mm ² /s	MNS 0480	1.8-5.0	3.008
4 Шүүгдэх температурын хязгаар, дээшгүй	°C	MNS 5800	-25.0/	-32.0/
5 Дөл үүсгэх температур, доошгүй	°C	MNS 0333	30.0	47.0
6 Цетаны 100° багагүй	-	Багажны аргачлалар	45.0	54.2
Цетаны индекс*	-		-	45.9
7 Нийт хүэрийн агуулга, нхгүй	mg/kg	ASTM D4294 CA3-22	2000	3014
8 Эх хавтгайн туршилт	-	MNS ISO 2160	тэжээртэй	1a
9 Механик хольцын агуулга, нхгүй	%	MNS 0322	0.0024	байхгүй
10 Усны агуулга, нхгүй	%	MNS 0332	0.02	байхгүй
11 Онго	-	MNS ISO 2049	-	0.0
12 Тоосонцорын хэрэг*	mg/g	MNS ISO 4406	-	20/18/13 ср-9

Тайлбар: *НХ-д өрсөгүй үзүүлэлт

Шинжилгээ хийсэн хиймич
Баталгаажуулсан лабораторийн эрхлэгч

Г.Уралхайч
М.Мидлгмаа

Энэхүү тайлан нь тухайн бэлтгэлийн хувьд хүчин хуульбарлан хэрэглэхийг хориглоно

Улаанбаатар хот, МОНГОЛ УЛС 14251

Scanned with CamScanner

000157

Зураг 4. Шатхууны сорилтын үр дүнгийн тайлан

2.4 Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, замыг тэмдэгжүүлэх, хуучирсан тэмдэг тэмдэглэгээг сэргээх

Үйлдвэрийн тээврийн зам дагуу 10 км/ц анхааруулах тэмдэг 1ш, үйлдвэрийн хашаа дотор 5 км/ц анхааруулах тэмдэг 1ш, чиглэл заах мэдээллэх тэмдэг 5 ш сэргээн шинчилсэн.





Зураг 5. Замын тэмдэг тэмдэглэгээ

2.5 Хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг ханган үйл ажиллагаа явуулах, хяналт мониторинг тогтмол хийж байх

Хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хяналт, мониторинг ээлжийн мастер болон ХАБЭА ажилтан хийж, далан сэтрэх задрахаас сэргийлэн далангийн өндөрлөгөө хүчтэлгийн тогтмол хийдэг.



Зураг 6. Үйлдвэрийн хаягдлын сан

2.6 Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг баримтлан үйл ажиллагаа явуулах

Үйлдвэрийн 79 ажилчдад ажлын байрны эмх цэгц, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, Хөдөлмөр аюулгүй байдлын мөрдөгдөж ажилах хууль тогтоомж, Байгууллагын дотоод журам, Хөдөрмөрийн гэрээ зэрэг мэдээллийг хүргэж ажилласан.



Зураг 7. Аюулгүй ажиллагааны дүрэм танилцуулах үйл явц

Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг баримтлан үйл ажиллагаа явуулснаар осол, гэмтэл гарах эрсдэл буурч, ажилчдын эрүүл мэнд хамгаалагдана. Үүний үр дүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн, аюулгүй, тасралтгүй явагдах нөхцөл бүрдэнэ.

2.7 Бохир хадгалах цооног, шугам хоолойд тогтмол хяналт шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй засах арга хэмжээг авах

Ахуйн бохир усны цооногт хуримтлагдсан бохир усыг 2025 оны 10 сарын 16 өдөр 5 тн машинаар нийт 4 удаа соруулж нийт 20 тн ахуйн бохир ус тээвэрлэн зайлуулсан байна.

Дулааны улиралд бохирын цооног шугам хоолойн үзлэг шалгалтыг хийдэг ба одоогоор эвдрэл гэмтэл гарсан тохиолдол байхгүй байна.



Зураг 8. Ахуйн бохир ус соруулж буй

2.8 Гоожиж асгарсан ШТМ-ыг шингээх материалыг ажлын талбайд бэлэн байлгах, мөн асгаралтаас сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээ, асгаралтыг мэдээлэх, хязгаарлах, цэвэрлэх дотоод журам боловсруулж мөрдүүлж ажиллах

2025 оны 06 сарын 05-ны өдрийн А/09 гүйцэтгэх захирлын тушаалаар эсгаралтын үед авах арга хэмжээ, асгаралт мэдээлэх, цэвэрлэх дотоод журам боловсруулж мөрдүүлж ажиллаж байна/Асгаралтын журмыг хавсаргав./

ШТМ гоожих асгарах үед шингээх зориулалт бүхий асгалтын иж бүрдэл 2ш (үйлдвэр/лабораторит) болон бохирдсон хөрс хадгалах цэгийг 2023 онд байгуулан 2024 онд доторлогоо хийж тос масло, химийн бодисоор бохирдсон хөрсийг тус цэгт хуримтлуулдаг. Одоогийн байдлаар ослын асгаралт үүсээгүй (5л их) бөгөөд бага хэмжээний тос масло асгарах үед богино долгионоор мэдээлэл аван ковшоор бохирдсон хөрсийг хуулан авч тус цэгт асгаж хайрган хучилтыг нэмэгдүүлдэг.



Зураг 9. Асгаралтын иж бүрдэл



Зураг 10. Бохирдсон хөрс хадгалах цэг

2.9 Хог хаягдлыг зориулалтын цэгт хаях, ангилах ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах

Баяжуулах үйлдвэрийн хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгадаг.

Үүнд:

- Ахуйн хатуу хог хаягдал /Сумын хог хаягдлын цэгт тээвэрлэдэг/
- Ахуйн шингэн хог хаягдал буюу ахуйн бохир ус /Бохир усны цооногт/
- Төмрийн хаягдал /Төмрийн хог хаягдал цуглуулах талбай /
- Хуванцар сав /Төмөр сав/
- Ашигласан тос масло /Тос масло цуглуулах цэг/
- Химийн бодисын шингэн хаягдал /Поошигт цуглуулан гэрээт компаниар устгууладаг/
- Химийн бодисын шуудай /Х Б шуудай хадгалах агуулах/
- Хүнсний хог хаягдал /Дулааны улиралд хүнсний ногооны хальс, өндөрний хальс зэргийг ялган авч поошигт хүрэн бууцтай хольж ялзруулдаг/




Зураг 11. Ахуйн хатуу хог хаягдлын цэг



Зураг 12. Хуванцар сав цуглуулах



Зураг 13. Төмрийн хог хаягдал цуглуулах талбай



Зураг 14. Ашигласан тос масло цуглуулах цэг




Зураг 15. Химийн бодисын сав баглаа шуудайн агуулах

2.10 Тоолуурын баталгаажуулалтын цаг тухай бүрт нь хийлгэх, тоолуур эвдрэл гэмтэл гарсан тухай бүр солих

Худаг №2,3,6 тоолуур 2025 оны 08 сарын 25-ны өдөр эвдэрсэн тул “Чандмань-Илч” ХХК-аар тоолуурын салгалтыг хийлгэн акт үйлдсэн.

Мөн тус компаниаар стандарт хэмжилзүйн газраар баталгаажсан гэрчилгээтэй тоолуурыг холбуулан лац тавьж акт үйлдсэн. /актыг хавсаргав/.



Зураг 16.Худаг №2 3 6 баталгаажуулалтын гэрчилгээ

2.11 Худгийн тоолуурын мэдээг сар бүр суманд тайлагнах

Худгийн тоолуурын баталгаажуулалтын сар бүр Даланжаргалан сумын байгаль орчны байцаагчаар тайлагнаж баталгаажуулдаг бөгөөд нийт ус зарцуулалт 62673 м³ ус ашигласан болно. Мөн баталгаажуулсан тоолуурын мэдээг Сав газрын захиргааны и-майл хаягаар илгээж ажилладаг болно.

Талст дөл ХХК-нийн 2025 оны 11-р сарын худгийн мэдээ

Огноо	Худаг-1	Худаг-2	Худаг-3	Худаг-4	Худаг-5	Худаг-6	НИЙТ м ³
	Тоолуурын заалт, м ³	Тоолуурын заалт, м ³	Тоолуурын заалт, м ³	Тоолуурын заалт, м ³	Тоолуурын заалт, м ³	Тоолуурын заалт, м ³	
2025.10.25	6522	3032	8856	12336	4937	12558	
2025.11.25	7813	3032	8856	12336	4937	15071	
Нийт	1291	-	-	-	-	2513	3804

Мэдээ гаргасан:

Байгаль орчны мэргэжилтэнЦэвэгмэд...../И.Цэвэгмэд/


Байгаль орчны улсын байцаагчС.Данларбаатар/



Худаг 1



Худаг 2



Худаг 3



Худаг 4



Худаг 5



Худаг 6

Зураг 17. Худгийн тоолуурын мэдээ

2.12 Унд ахуйн болон бусад хэрэгцээнд усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах, ус хэмнэлтэт эко цорго нэвтрүүлэх

Усыг ариг гамтай ашиглах зорилгоор ажилчдын кемпийн болон оффисын ариун цэврийн өрөөний угаалтуурт 2 ш эко цорго суурьлуулав. Ус хэмнэх эко цорго суурьлуулснаар хэрэгцээгүй ус гоожуулалт, алдагдал багасна.



Зураг 18. Ус хэмнэгч эко цорго суурьлуулсан байдал

2.13 Хур борооны усыг хуримтлуулан тоосжилт, зам усалгаа, ногоон байгууламж услахад ашиглах

Хур борооны усыг поошигт цуглуулан кемпийн ойролцоох хүлэмжний усалгаанд ашигласнаар усны эх үүсвэрийг үр ашигтай ашиглаж байна.

2.14 Худгийн барилга байгууламжийг сайжруулах, эрүүл ахуйн бүс тогтоох

2-6 худгийн байшинг янзласан будаж сэргээсэн.



Зураг 19. Худаг №2

2.15 Баяжуулах үйлдвэрийн ургамлын аймгийг тодорхойлох цэгт ургамлын мониторинг хийх

Ургамлын мониторингийн судалгааг нэг цэгт ($45^{\circ}55'55.61''N$ $109^{\circ}05'15.5''E$) өндөр 1073м 2025 оны 09 сарын 06 ны өдөр ургамлын мониторинг хийж гүйцэтгэсэн. Элсэрхэг шавранцар хөрс бүхий нутагт орших бэл хормойгоор хялгана-агь-тэсэг-харгана зэрэг ургамалжилт тархах бөгөөд 1*1м² талбайн тусгагийн бүрхэц 35-40%, хайрга чулуу 10-15%, ил хөрс 35-45% тус тус эзлэх бөгөөд 3-4 зүйл бүртгэгдсэн.

2024 онд ургамлын мониторингийн судалгаагаар 1*1м² талбайн тусгагийн бүрхэц 25-30%, хайрга чулуу 1-3%, ил хөрс 15-20%, хагд 12-15% тус тус эзлэх байсан нь 2025 онд ургамалжилт харцуулахад ургамлын ургалжилтын бүрхэц нэмэгдсэн, хайрга чулуу болон ил хөрсний эзлэх хувь нэмэгдсэн байна.


Бүлгэмдлийн нэр	Зонхилогч, дэд зонхилогчийн нэр	Дагалдах зүйл
Шарилж Хазаар өвс	Шарилж	Хазаар өвс



Зураг 20. Ургамлын бичиглэл хийх талбайг (1x1 м) харуулсан байдал

2.16 Хууль бусаар ан амьтан агнах, гаршуулах, гэрэл чийдэн тусгаж сэлгүүцэж амьтдыг айлгах, хөөн зайлуулах үйлдлийг хатуу хориглоно. Ажилчдад мэдлэг олгох сургалт хийх

Хууль бусаар ан амьтан агнах, гаршуулах, гэрэл чийдэн тусгаж сэлгүүцэж амьтдыг айлгах, хөөн зайлуулах үйлдлийг хатуу хориглох танилцуулгыг ажилчдад мэдлэг олгох сургалтыг 2025 оны 9 сарын 22-ны өдөр зохион байгуулав.



Зураг 21. Сургалтын орсон баримт

2.17 Үйлдвэрийн цахилгаан шугам болон сумаас үйлдвэр чиглэлийн өндөр хүчдэлд шувуу үргээгч байршуулах

Үйлдвэрийн цахилгаан шугам болон сумаас үйлдвэр чиглэлийн өндөр хүчдэлд 2025.10.31-ний өдөр 2 ширхэг шувуу үргээгч байршуулан ажилсан.



Зураг 22. Шувуу үргээгч суурьлуулсан өндөр хүчдэл

3. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах

Ахуйн хатуу хог хаягдлыг Даланжаргалан сумын ЗДТГ-тай байгуулсан гэрээний дагуу сумын нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зайлуулдаг.



Зураг 23. Ахуйн хатуу хог хаягдлын тээвэрлэж буй зураг

3.2 Хүнсний хог хаягдлыг ялган авч түргэн ялзруулагч ашиглан компост бордоо хийж хүлэмжийг бордох

Дулааны улиралд хүнсний ногооны хальс, өндөрний хальс зэргийг ялган авч пошигт хүрэн бууцтай хольж ялзруулан, кемпийн ойролцоо байрлах ногооны хүлэмжийг борддог.

Хүнсний хог хаягдлыг ялган авч бордоо бэлдснээр хог хаягдал багасна.



Зураг 24. Хүнсний хог хаягдлыг газар дээр нь ялган авч ялзруулан авч буй зураг

3.3 Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх

Хог хаягдлын гэрээг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ-тай гэрээ байгуулж, төлбөр болох 5 сая.төг төлсөн. “Түмэн Эгшиг” ХХК-тай аюултай хог хаягдал устгуулах гэрээ байгуулсан. /ахуйн хог хаягдлын гэрээ болон аюултай хог хаягдлын гэрээг хавсаргав/.

3.4 Ахуйн бохир усны цооногт ариутгах, халдваргүйжүүлэх, ариутах

Ахуйн бохир усны цооногт тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, бохирын үнэр, нянгийн үржлийг бууруулах арга хэмжээг авсан. Ариутгалын бодисоор хлорын уусмал хэрэглэдэг.



Зураг 25. Ариутгал, халдваргүйжүүлэлт

3.5 Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх

Үерийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, зорилгоор үйлдвэрийн хашааг тойруулан далан зогоон татсан.

3.6 Хаягдал усны хяналт шинжилгээ мониторингийг цах тухайд хийх

Хүснэгт 3. Ахуйн бохир болон хаягдлын далангийн уснаас дээж авсан огноо лаб-ийн мэдээлэл

Огноо	Дээж авсан лаборатори	Үзүүлэлт
Ахуйн бохир ус		
2025.09.08	“Нарт Шүүн Консалтинг” ХХК лаборатори	Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.
2025.10.24	“Нарт Шүүн Консалтинг” ХХК лаборатори	Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.
Хаягдлын далангийн ус		
2025.06.09	Дорноговь аймгийн УЦУОШТ	Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.
2025.10.24	“Нарт Шүүн Консалтинг” ХХК лаборатори	Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага.

3.7 Ашигласан тос масло хадгалах цэгийн бүрэн бүтэн байдлыг хангах

Ашигласан тос маслын хадгалах цэг нь хатуу хучилттай талбайтай тэмдэг тэмдэглэгээтэй, засварын газраас гарсан ашигласан тос маслыг төмөр поошигт хуримтлуулан гэрээт компанид нийлүүдэг.



Зураг 26. Ашигласан тос масло хадгалах цэг

3.8 Ашигласан тос маслийг мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж зайлуулах

“Клийн Ойл ХХК” ашигласан тос масло дахин боловсруулах үйлдвэрт 200 литр ашигласан тос маслийг нийлүүлсэн.

НХМянгт БМ-2 Саягын сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 247 тоот тушаалын хансралт

ОРЛОГЫН БАРИМТ № _____

“Кевин Инвест” ХХК
(байгууллагын нэр) 2025 он 09 сар 16 өдөр

(байтсан нийлүүлэгчийн нэр) Давгалдах баримт № _____

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг дугаар	Код	Хэмжээ мэдэгдэх	Нэгж бүрийн үнэ	Хүлээн авсан	
					Тоо	Үнэ
1	Ажиргаас сон тос		м	-	200	-
Дүн						

Тэмдэг: Утгаалсан өсгөн ад хөргөгчөөс
 Хураан авалч
 Шалтгаан нэгтгэн бодогч

М. Батбаяр
С. Монгол

Зураг 27. 200 л тос масло тушаасан баримт

3.9 Химийн бодисын шингэн үлдэгдэл болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах

2025 оны 09 сарын 04-ны өдөр Химийн бодисын шуудай 900кг, уусмал 20л, химийн бодисын сав шил 23 ш “Түмэн Эгшиг” ХХК гэрээ байгуулж устгуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хансралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ
№ 009
Дагалдах бичгийн дугаар: _____
(шаарбалцаагүй, шаарбалцсан үзэгдэл үзэгдсэн үзэгдсэн)

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: _____
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: “ТАЛСТ ДӨЛ” ХХК

2. Аюултай хог хаягдалыг хүлээлгэн өгсөн:
Овог нэр: Албан тушаалтан ХАБЭА Огноо: 2025 он 09 сар 05 өдөр

3. Түвшрүүлэгчийн талаарх мэдээлэл:
1/ Түвшрүүлэгчийн хэрэгсэлийн үзэмж дугаар: _____ Түвшрүүлэгчийн бүртгэлийн дугаар: 0000022

4. Аюултай хог хаягдалын талаарх мэдээлэл:

Аюултай хог хаягдалын нэр	Аюулын ангилалын тэмдэг	Савны		Хэмжээ дугаар	Төрөл	Хэмжээ	Нэгж үгт Эжжэл	Аюултай хог хаягдалын код
		ны бүлэг	дугаар					
1. Хаягдал шуудай	X			900			кг	150119
2.								
3.								
4.								

5. Түвшрүүлэх үед ашигдсан нэмэлт хаваринагаа, мэдээлэл:
Тусгай Зориулалтын тээврийн хэрэгсэл

6. Үл зөвшөөл:

8. Аюултай хог хаягдалыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгжийн нэр: ТҮМЭН ЭГШИГ ХХК
Түвшрүүлэгч ХХК-ийн бүртгэлийн дугаар: -000022
Аюултай хог хаягдалыг хүлээн авсан:
Овог нэр: Түмэн эгшиг ХХК Гарын үсэг: _____ Огноо: 2025 он 09 сар 05 өдөр
Ч. Овоожаргал Уйлдвэрийн дарга

ТҮМЭН ЭГШИГ ХХК

ХАМТЫН ДӨГТ ВАНС
ХАЯГДАЛ БОЛОВСГОХ
САВ БАГЛАА БОССОГО
ВАЙСЫН БОСООХ ТУХАЙ

НИЙГЭМЭР
ТЕХНИКИЙН АЗВА

称 重 单

序号:	0936
日期:	2025-09-04
时间:	10.01.41
车号:	07833
货号:	000
毛重:	6150 (kg)
皮重:	5250 (kg)
净重:	900 (kg)



Зураг 28. Химийн бодисын шуудай болон үлдэгдэл хүлээн авсан акт болон ачилтын үйл явц

4.10. Ашиглалт дууссан эд ангийг тусгай талбайд хадгалан хаягдал төмрийг дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх

Хаягдал төмөр хадгалах цэгт ашиглалт дууссан эд анги төмрийн хадгалдаг. 2025 оны 10 сард “Пийс стийл групп” ХХК-ийн налайхд байрлах төмөр авах цэгт 0,8 тонн хаягдал төмрийг ачуулж акт үүлдсэн.



БАРАА, МАТЕРИАЛ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

Нийлүүлэгч: “Кевин инвест” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэр

Хүлээн авагч: Пийс стийл групп ХХК

2025 оны 10 дүгээр сарын-ын өдөр хаягдал төмөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт дахь Кевин инвест ХХК-ийн баяжуулах үйлдвэрийн хэсэгт хүлээлгэн өгөв.

№	Материалын нэрс	Тоо хэмжээ	Хэмжих нэгж
1	Хаягдал төмөр	0.8	тонн

Хүлээлгэн өгсөн:

Талст дел ХХК-ийн үйлдвэрийн дарга *Б. Батбаяр* Б.Батбаяр

Хүлээн авсан:

Пийс стийл групп ХХК ийн Кассын нярав *Ц. Пүрэвсүрэн* Ц. Пүрэвсүрэн




Зураг 29. Төмөр хадгалах талбай болон хүлээлгэн өгсөн акт

4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих

Ажлын байр болон үйлдвэрт ажиллаж байгаа ажилчдад аюулгүй ажиллагааны дүрэм журмыг танилцуулан урьдчилсан, 2025 оны 07 сарын 26 давтан зааварчилгаанд нийт 79 ажилчдад танилцуулан шалгалт авсан болно.



Шөнийн ээлж 2025.10.14-10.24

Ажлын байрны нэр	Ажилтны нэр	Ногоон алгатав	5 хуруун цавган	Маск	Чихэвч	Хошууч	Гарын усг
1 Мастер	С.Одбаяр						
	Т.Отгонбаатар	8			1	10	
2 Булгах	Д.Жамбал	8			1	10	
	Б.Дорждан	8			1	10	
	Э.Энхбат	8			1	10	
	Б.Сансар	8			1	10	
3 Тээрэм	Б.Чулуун-Ордина	8		10	1		
4 Шуух	Х.Түвшиндэлгэр	8		10	1		
	М.Жавзаа	8		10	1		
5 Савлах	Н.Бадмацэцэг	8		10	1		
	У.Долгормаа	8		10	1		
	Н.Адьяажаа	8		10			
6 Кочш	Н.Нармандах	8		10	1		
	Б.Нимлэнгэдэр	4	4				
7 Хово	Ж.Цэрэнбаатар	4	4				
				5			
8 Галч	Б.Ариунгодох	4	4			10	
	С.Баяр	4	4			10	
	В.Бундгалар	4	4				
	Д.Ганзориг	4	4			10	

ХАБЭА-н өмнөдөр 10/14 А.

4.2 Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх

Үйлдвэрийн ажилчдад ажлын байрны эмх цэгц, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, Хөдөлмөр аюулгүй байдлын мөрдөгдөж ажилах хууль тогтоомж, Байгууллагын дотоод журам, Хөдөрмөрийн гэрээ зэрэг мэдээллийг хүргэж ажилласан.

4.4 Хүчтэй салхи, шуурга үед аян замд гарахгүй

Хүчтэй салхи шуургатай үед тээвэр болон гадаа ажил гүйцэтгэж байгаа ажилчдыг бүрэн зогсоох үйл ажиллагаа авч хэвшсэн.

4.5 Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах

Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах зорилгоор тогтмол сургалт зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, дүрэм журмыг мөрдүүлэх арга хэмжээг авдаг. Мөн ажил үүргийн онцлогт тохирсон хамгаалах хувцас, хэрэглэл (ажлын хувцас, гутал, бээлий, нүдний шил, амны хаалт гэх мэт)-ээр бүрэн хангаж, тэдгээрийн хэрэглээ, бүрэн бүтэн байдалд хяналт тавьдаг. Ажлын байрны орчны цэвэр байдал, агааржуулалт, гэрэлтүүлэг болон ариун цэврийн нөхцөлийг хангаж, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах үзлэг тогтмол хийдэг.

4.6 Гал унтраах багаж хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр байрлуулах, галын хорны даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах

Гал унтраах багаж хэрэгсэл болон галын аюулгүй ажиллагааны самбарыг хүрэлцээтэй хэмжээгээр байршуулж, галын хорны даралт болон бүрэн бүтэн байдлыг тогтмол хянадаг.

4.7 Галын дүгнэлтийг мэргэжлийн байгуулгаар гаргуулах

Дорноговь аймгийн Онцгой байдлын газраас “Амрах байр, оффис” “ШТС” “Жонш баяжуулах үйлдвэрийн байр” гэсэн 3 галын дүгнэлттэй ажиллаж байна.

ШТС болон Үйлдвэрийн байрны галын дүгнэлтийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан сунгуулахаар хүсэлт өгсөн болно.

5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Даланжаргалан сумын төв замын ард байрлах мод тарих талбайг тойруулан хашаа барих

2025 оны БОМТ-ын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын мод тарих талбайг хашаалах ажлыг хийж гүйцэтгэн. Ажлыг гүйцэтгэсний дараа сумын байгаль орчны байцаагчид ажлын тайлан хүлээлгэн өгч баталгаажуулсан.

5.2 Даланжаргалан сумын мод тарих хашаалсан талбайд мод тарих

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” хүрээнд Даланжаргалан сумын наадмын талбайд 500 ш хайлаасыг сумын байгаль орчны байцаагч Дандарбаатар хүлээлгэн өгсөн болно.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал

№	Нэр,төрөл	Хэмжих нэгж	Нийт үнэ
1	Хашаа 1000 метр	төг	40 000 000
2	500 ш хайлаас	төг	1 500 000
3	Гагнуурчин цалин	төг	5 000 000
Нийт санхүүгийн зарцуулалт 46 500 000			



Зураг 30. Мод тарих талбайд хийгдсэн хашааны зураг


6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

6.1 Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TPS, PM2.5, PM10, SO2, NO2

1. Агаар дахь нийт тоосны агууламж, SO2, NO2-ийн хэмжилтийг 6 сард кемп, баяжуулах үйлдвэр, хаягдлын далан гэсэн 3 цэг шинжлэв. Үр дүнг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5. TPS, SO2, NO2 агууламж


№	Дээж авах цэгийн нэр	Хүхэрлэг хий SO2 мг/м3	Азотын давхар исэл, NO2 мг/м3	Нийт тоосны агууламж мг/м3
1	Кемп	0.004	0.017	0.147
2	Баяжуулах үйлдвэр	0.011	0.014	0.337
3	Үйлдвэрийн бүс	0.012	0.029	0.285
ЗДХ	MNS4584:2025	0.450	0.200	0.500



2. 2025 оны 06 сарын 10 болон 09 сарын 22 өдөр НТ-9600 багаж ашиглан PM2.5 PM10 тоос тоосоцрыг хэмжсэн болно. Хэмжилтийн үр дүнд Тээврийн зам, үйлдвэрийн орчи болон дотор гэсэн 3 цэгт PM2.5 MNS 4585:2016 стандартын ЗДХ-нээс хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. PM2.5 PM 10 тоосны агууламж

№	Дээж авсан цэгийн нэр	2025/09/22		2025/06/10	
		PM2.5	PM10	PM2.5	PM10
1	Хаягдлын сан орчим	10	0	8	1
2	Үйлдвэр орчим	100	0	56	2
3	Үйлдвэр дотор	430	1	300	1
4	Тээврийн зам	60	0	43	0
5	Ажилчдын байр орчим	10	0	5	0
ЗДХ	MNS4585:2016 (20минутын хэмжилт)	50	100	50	100



6.2 Гүний худгийн усны чанар/Улиралд 1 удаа/

1. 2025 оны 06 сарын 09-ны өдөр ДГА-ийн УЦУОШТ-ийн мэргэжилтнүүд ирж ундны ус болон ахуйн уснаас дээж авч лабораторидоо шинжилсэн болно.

Дүгнэлт:

Ахуйн усны магнийн ион /Mg/ “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартийн ЗДХ-нээс 17.5 мг/л хэтэрсэн үзүүлэлттэй байна. Харин ундны ус нь стандартын шаардлага хангаж байна.

2. 2025 оны 09 сарын 08-ны өдөр “Нарт Шүүн Консалтинг” ХХК лабораторит ундны усны дээж авч шинэжлүүлсэн.

Дүгнэлт:

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, магнийн бүлэг, 2 төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна.

3. 2025 оны 10 сарын 24-ны өдөр “Нарт Шүүн Консалтинг” ХХК лабораторит үйлдвэрийн ахуйн уснаас дээж авч шинэжлүүлсэн.

Дүгнэлт:

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, магнийн бүлэг, 2 төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, маш хатуу ус байна.

6.3 Ахуйн бохир ус /Жилд 2 удаа/

Ахуйн бохир усыг 2025 оны 09 болон 10 саруудад “Нарт Шүүн Консалтинг” ХХК дээж өгч шинжлүүлсэн.

9 болон 10 сарын ахуйн бохир усны шинжилгээний үр дүнг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага **MNS 4943:2015** стандарттай харьцуулахад 09 сарын дээжний Нийт хром буюу (Cr) 0.27 мг/л-аар ЗДХ-ээс давсан үзүүлэлттэй байна. Бусад үзүүлэлт болох умбуур бодис, ууссан хүчилтөрөгч, Cu, Cd, Ni, Pb, Zn ЗДХ-нээс даваагүй. Мөн гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илгээрүй байна.

6.4 Хаягдлын далангийн ус /жилд 2 удаа/

1. Хаягдлын далангийн усыг 2025 оны 06 сарын 04-ны өдөр Дорноговь аймгийн УЦУОШТ-ийн мэргэжилтнүүд ирж дээв авч лабораторит шинжлүүлсэн.

Тус шинжилгээний үр дүнг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандарттай харьцуулахад жинлэгдэх бодис, перманганатын исэлдэх чанар болон биологийн хэрэгцээт хүчилтөрөгч их гарсан байна.

2. Хаягдлын далангийн усыг 2025 оны 10 сарын 24-ны өдөр “Нарт шүүн консалтинг” ХХК лабораторит өгч шинжлүүлэв.

Тус шинжилгээний үр дүнг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандарттай харьцуулахад хартуугага буюу (Pb) 0.07 мг/л-аар ЗДХ-ээс давсан үзүүлэлттэй байна. Бусад үзүүлэлт болох умбуур бодис, ууссан хүчилтөрөгч, Cu, Cd, Ni, Pb, Cr, Zn ЗДХ-нээс даваагүй. Мөн гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илгээрүй байна.

6.5 Хөрсний ерөнхий химийн шинжилгээ /жилд 2 удаа/


1. 2025 оны 06 сарын 04-ны өдөр Дорноговь аймгийн УЦУОШТ-ийн мэргэжилтнүүд ирж Баяжуулах үйлдвэр, хаягдлын далан, мод тарих талбай гэсэн 3 цэгт хөрсний агрохимийн шинжилгээ авч лабораторит шинжлүүлсэн.

2. 2025 оны 10 сарын 24-ны өдөр “Нарт шүүн консалтинг” ХХК лабораторит баяжуулах үйлдвэр болон кемп харьцуулах хөрс гэсэн 3 цэгт хөрсний агрохимийн шинжилгээ авч лабораторит шинжлүүлсэн.

6.6 Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж /Жилд 2 удаа/


1. 2025 оны 09 сарын 08 өдөр “Нарт Шүүн Консалтинг” ХХК лабораторит үйлдвэрийн 7 цэгээс хөрсний дээж авч хүнд металл шинжлүүлсэн.

Дүгнэлт: Хром (Cr) болон хартугалга(Pb) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2019 стандартын ЗДХ-нээс давсан боловч хортой агууламжид хүрээгүй байна.



2. 2025 оны 10 сарын 24 өдөр “Нарт Шүүн Консалтинг” ХХК лабораторит үйлдвэрийн 7 цэгээс хөрсний дээж авч хүнд металл шинжлүүлсэн.

Дүгнэлт: Хартугалга(Pb) Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2019 стандартын ЗДХ-нээс давсан боловч хортой агууламжид хүрээгүй байна.



6.7 Ургамлын зүйлийн бүрдэл ургамлын тусгаг бүрхэц, 1 м² талбайгаас газрын дээрх биомасс авах

Ургамлын мониторингийн судалгааг нэг цэгт (45°55'55.61"N 109°05'15.5"E) өндөр 1073м 2025 оны 09 сарын 06 ны өдөр ургамлын мониторинг хийж гүйцэтгэсэн. Элсэрхэг шавранцар хөрс бүхий нутагт орших бэл хормойгоор хялгана-агь-тэсэг-харгана зэрэг ургамалжилт тархах бөгөөд 1*1м талбайн тусгагийн бүрхэц 35-40%, хайрга чулуу 10-15%, ил хөрс 35-45% тус тус эзлэх бөгөөд 3-4 зүйл бүртгэгдсэн таарах зүйлийн тоог хүснэгтээр үзүүлэв.










Бүлгэмдлийн нэр	Зонхилогч, дэд зонхилогчийн нэр	Дагалдах зүйл
Шарилж Хазаар өвс	Шарилж	Хазаар өвс



